НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын  2025 оны санхүүгийн тайланд хийсэн  аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/060/НА-СТА-ОНӨҮГ


Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugs.s@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас: 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН** .......... 4
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** .......... **4**
2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан .......... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .......... 7
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 9
3.2 АЛБАН ШААРДЛАГА .......... 9
3.3 ЗӨВЛӨМЖ .......... 9
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 850
танай ______ -ны № ______ -т

УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Т.БАТБИЛЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь Замын сангийн хөрөнгөнөөс 43,078.3 сая төгрөг, Нийслэлийн засаг даргын нөөц сангаас 2,539.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай 13 гэрээт ажил, Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай 18 гэрээт ажил хийж 96.0 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\... 1436050817

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2024 оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | **-** | **-** |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 2,280,757,185.23 | 605,312,766.05 |
| 1.1.2 | Дансны авлага | 30,576,690,987.83 | 3,835,732,249.27 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 158,399.62 | 63,970.23 |
| 1.1.4 | Бусад авлага | 2,182,841,930.50 | 1,840,597,034.50 |
| 1.1.6 | Бараа материал | 4,946,954,070.88 | 5,099,158,347.24 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 5,712,972,727.27 | 2,633,692,309.17 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 18,821,566.83 | 20,576,380.70 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **45,719,196,868.16** | **14,035,133,057.16** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | **-** | **-** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 3,348,792,800.39 | 4,181,850,129.40 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **3,348,792,800.39** | **4,181,850,129.40** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **49,067,989,668.55** | **18,216,983,186.56** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 462,014,103.52 | 1,070,747,899.98 |
| 2.1.1.3 | Татварын өр | 4,520,965,988.85 | 5,172,317,954.52 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 33,058,048,179.09 | - |
| 2.1.1.9 | Нөөц / өр төлбөр / | 1,802,432,703.17 | 1,588,947,979.47 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 84,133,760.10 | - |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **39,927,594,734.73** | **7,832,013,833.97** |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | - | 1,475,498,000.00 |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **1,475,498,000.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **39,927,594,734.73** | **9,307,511,833.97** |
| 2.3.1 | Төрийн өмч | 7,765,127,992.86 | 7,765,127,992.86 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,167,698,193.21 | 1,167,698,193.21 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 207,568,747.75 | (23,354,833.48) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **9,140,394,933.82** | **8,909,471,352.59** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **49,067,989,668.55** | **18,216,983,186.56** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 39,395,058,567.14 | 46,473,153,425.73 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 37,943,637,657.84 | 45,064,689,346.31 |
| 3 | **Нийт ашиг/алдагдал/** | **1,451,420,909.30** | **1,408,464,079.42** |
| 9 | Хүүний орлого | 20,606,410.86 | 26,356,130.75 |
| 10 | Бусад орлого | 23,782,131.11 | 36,842,442.68 |
| 12 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,196,243,091.80 | 1,366,102,087.92 |
| 13 | Санхүүгийн зардал | 1,874,523.18 | 1,939,357.11 |
| 14 | Бусад зардал | 254,816,269.90 | 77,014,799.09 |
| 20 | **Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/** | **42,875,566.39** | **26,606,408.73** |
| 21 | **Орлогын албан татварын зардал** | 6,078,526.64 | 2,645,000.00 |
| 22 | **Татварын дараах ашиг алдагдал** | **36,797,039.75** | **23,961,408.73** |
| 24 | **Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/** | **36,797,039.75** | **23,961,408.73** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **7,765,127,992.86** | **1,167,698,193.21** | **170,771,708.00** | **9,103,597,894.07** |
| 2 | Залруулсан үлдэгдэл | 7,765,127,992.86 | 1,167,698,193.21 | 170,771,708.00 | **9,103,597,894.07** |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал ) | - | - | 36,797,039.75 | **36,797,039.75** |
| **4** | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **7,765,127,992.86** | **1,167,698,193.21** | **207,568,747.75** | **9,140,394,933.82** |
| 5 | Залруулсан үлдэгдэл | 7,765,127,992.86 | 1,167,698,193.21 | 207,568,747.75 | **9,140,394,933.82** |
| 6 | Өмчид гаргасан өөрчлөлт | - | - | (237,520,339.96) | **(237,520,339.96)** |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | (17,364,650.00) | **(17,364,650.00)** |
| 8 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал ) | - | - | 23,961,408.73 | **23,961,408.73** |
| **9** | **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **7,765,127,992.86** | **1,167,698,193.21** | **(23,354,833.48)** | **8,909,471,352.59** |

**2.**4 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1.1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **49,669,515,132.48** | **44,202,094,435.80** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 49,648,150,766.31 | 44,165,473,993.12 |
| 1.1.4 | Бусад мөнгөн орлого | 21,364,366.17 | 36,620,442.68 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **51,109,302,732.09** | **45,886,530,335.73** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 2,456,391,154.00 | 3,189,242,622.04 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 745,987,210.00 | 980,516,541.85 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 46,468,328,402.96 | 37,123,451,781.20 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 89,672,991.42 | 356,578,110.96 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,820,000.00 | 1,710,363.64 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 344,027,061.09 | 271,431,032.66 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 9,822,127.00 | 242,862.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 992,253,785.62 | 3,963,357,021.38 |
| **1.3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(1,439,787,599.61)** | **(1,684,435,899.93)** |
| **2** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **2.1** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **20,606,410.86** | **26,356,130.75** |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 20,606,410.86 | 26,356,130.75 |
| **2.2** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **-** |
| **2.3** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **20,606,410.86** | **26,356,130.75** |
| **3** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн** | **-** | **-** |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн** | **-** | **17,364,650.00** |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | | 17,364,650.00 |
| **3.3** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | (17,364,650.00) |
| **4** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **(1,419,181,188.75)** | **(1,675,444,419.18)** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **2,280,757,185.23** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **605,312,766.05** |

### 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | 2024 оны гүйцэтгэл | 2025 он | | Харьцуулалт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:*** | | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **2024 гүйц/2025гүйц** | **Хувь** | **2025 төл/2025гүйц** | **Хувь** |
| Авто зам, замын байгууламж барих, засвар, арчлалтын ажил | 34,033,252.3 | 45,589,243.9 | 45,341,040.1 | 11,307,787.8 | 24.9 | (248,203.8) | (0.5) |
| Сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал | 2,823,342.8 | 560,000.0 | - | (2,823,342.8) | | (560,000.0) | |
| Хайс, хашлаганы засвар арчлалт | 1,038,227.6 | - | - | (1,038,227.6) | | - | |
| Гүүрийн байгууламж, нүхэн гарцны ашиглалт үйлчилгээ | 395,717.8 | 699,907.3 | 619,731.3 | 224,013.5 | 36.1 | (80,176.0) | (12.9) |
| Асфальт бетон хольц үйлдвэрлэлтийн орлого | 1,022,691.3 | 300,000.0 | 443,445.0 | (579,246.3) | (130.6) | 143,445.0 | 32.3 |
| Төлбөртэй авто зогсоолын орлого | 17,253.0 | - | - | (17,253.0) | | - | |
| Бусад орлого | 108,962.3 | - | 132,135.6 | 23,173.3 | 17.5 | 132,135.6 | 100.0 |
| **Нийт орлогын дүн** | **39,439,447.1** | **47,149,151.2** | **46,536,352.0** | **7,096,904.9** | **15.3** | **(612,799.2)** | **(1.3)** |
| Цалин | 2,913,875.0 | 5,072,131.1 | 3,890,562.5 | 976,687.5 | 133.5 | (1,181,568.6) | (30.4) |
| Хоол унааны хөнгөлөлтийн зардал | 188,271.0 | 509,112.0 | 237,714.0 | 49,443.0 | 126.3 | (271,398.0) | (114.2) |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 404,382.4 | 719,980.4 | 534,892.6 | 130,510.2 | 132.3 | (185,087.8) | (34.6) |
| Удирдах зөвлөлийн зардал | 29,700.0 | 64,380.1 | - | (29,700.0) | - | (64,380.1) | |
| Сэлбэг хэрэгсэл | 239,738.0 | 296,758.4 | 279,098.7 | 39,360.7 | 116.4 | (17,659.7) | (6.3) |
| Ашиглалтын зардал | 123,481.7 | 128,040.0 | 133,168.6 | 9,686.9 | 107.8 | 5,128.6 | 3.9 |
| Түрээсийн зардал | 680,831.3 | 1,200,000.0 | 4,044,685.4 | 3,363,854.1 | 594.1 | 2,844,685.4 | 70.3 |
| Тос, тосолгооны зардал | 81,406.6 | 89,639.0 | 68,831.1 | (12,575.5) | 84.6 | (20,807.9) | (30.2) |
| Хөдөлмөр хамгаалалын зардал | 33,490.0 | 34,760.0 | 22,391.9 | (11,098.1) | 66.9 | (12,368.1) | (55.2) |
| Түүхий эд материал | 3,488,401.5 | 5,076,970.0 | 4,054,263.9 | 565,862.4 | 116.2 | (1,022,706.1) | (25.2) |
| Урсгал засварын зардал | 13,698.9 | 180,000.0 | 40,000.0 | 26,301.1 | 292.0 | (140,000.0) | (350.0) |
| Шатахуун | 1,306,417.7 | 1,492,105.0 | 1,289,912.9 | (16,504.8) | 98.7 | (202,192.1) | (15.7) |
| Шуудан холбоо, бичиг хэрэгсэл | 15,857.4 | 31,283.0 | 29,355.3 | 13,497.9 | 185.1 | (1,927.7) | (6.6) |
| Сургалт | 17,890.0 | 10,210.0 | 7,195.0 | (10,695.0) | 40.2 | (3,015.0) | (41.9) |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 869,637.5 | 873,875.3 | 624,787.9 | (244,849.6) | 71.8 | (249,087.4) | (39.9) |
| Албан журмын даатгал, татвар | 24,927.2 | 37,000.0 | 21,395.8 | (3,531.4) | 85.8 | (15,604.2) | (72.9) |
| Хангамжийн материал | 40,432.9 | 46,118.8 | 27,354.5 | (13,078.4) | 67.7 | (18,764.3) | (68.6) |
| Нийгмийн арга хэмжээний зардал | 189,610.5 | 223,000.0 | 48,078.6 | (141,531.9) | 25.4 | (174,921.4) | (363.8) |
| Ахмадын сан | 33,583.0 | 50,721.3 | 13,600.0 | (19,983.0) | 40.5 | (37,121.3) | (273.0) |
| Зар сурталчилгаа | - | 5,500.0 | 1,500.0 | 1,500.0 | | (4,000.0) | (266.7) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Он дамнасан ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 28,655,142.2 | 25,937,307.4 | 21,260,509.3 | (7,394,632.9) | 74.2 | (4,676,798.1) | (22.0) |
| 2025 оны гэрээт ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | - | 4,941,700.0 | 9,842,522.6 | 9,842,522.6 | | 4,900,822.6 | 49.8 |
| Гамшгийн үеийн менежментийн зардал | 23,560.0 | 24,025.0 | 19,025.0 | (4,535.0) | 80.8 | (5,000.0) | (26.3) |
| Үйл ажиллагааны бус зардал | 22,236.7 | 60,000.0 | 18,900.0 | (3,336.7) | 85.0 | (41,100.0) | (217.5) |
| **Нийт зардлын дүн** | **39,396,571.5** | **47,104,616.8** | **46,509,745.6** | **7,113,174.1** | **118.1** | **(594,871.2)** | **(1.3)** |
| **Татварын өмнөх ашиг** | **42,875.6** | **44,534.5** | **26,606.4** | **(16,269.2)** | **62.1** | (17,928.1) | **(67.4)** |
| Орлогын татвар | 6,078.6 | 4,453.5 | 2,645.0 | (3,433.6) | 43.5 | (1,808.5) | (68.4) |
| **Цэвэр ашиг, алдагдал** | **36,797.0** | **40,081.1** | **23,961.4** | **(12,835.6)** | **65.1** | (16,119.7) | **(67.3)** |
| Орлогын нэг төгрөгт ногдох зардал | **1.0** | **1.0** | **1.0** | (0.0) | 99.9 | (0.0) | (0.0) |
| Нийт авлага | 4,000,283.0 | 3,123,383.0 | 8,042,833.3 | 4,042,550.3 | 201.1 | 4,919,450.3 | 61.2 |
| Нийт өр төлбөр | 4,021,017.0 | 4,348,160.0 | 7,502,261.5 | 3,481,244.5 | 186.6 | 3,154,101.5 | 42.0 |
| Хөрөнгө оруулалт | 560,000.0 | 712,000.0 | | (560,000.0) | | (712,000.0) | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,475,498.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,475,498.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

*Залруулсан алдаа:*

Нийслэлийн засаг даргын А/1528 дугаарт захирамжийн дагуу 1,475,498.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг төрийн өмч дээр бүртгэж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 20 буюу Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулгыг хангахгүй тул залруулав.

Нийт илрүүлсэн 157,366.3 мянган төгрөгийн зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 236,599.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.2 АЛБАН ШААРДЛАГА

***Илрүүлэлт 1*:** Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 41,744.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т *“Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна"*, Засгийн газрын 2024 оны *“Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”* 02 дугаар тогтоолтой тус тус нийцхгүй, санхүүгийн тайлагналын *“нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”* батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

***Илрүүлэлт 2*:** Тайлант хугацаанд 68,150.9 мянган төгрөгийн өглөг дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 ЗӨВЛӨМЖ

***Илрүүлэлт 1*:** Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүнг ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүнтэй тулгахад ерөнхий журналд 47,470.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо*

*хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм*" гэж заасантай нийцэхгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>*** Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийслэлийн засаг даргын А/1528 дугаарт захирамжийн дагуу 1,475,498.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг төрийн өмч дээр бүртгэж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 20 буюу Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулгыг хангахгүй тул залруулав. | 1 | 1,475,498.0 | | | 1 | 1,475,498.0 | 1 | 1,475,498.0 | | |
| **Дүн** | **1** | **1,475,498.0** | | | **1** | **1,475,498.0** | **1** | **1,475,498.0** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 47,470.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна. | 1 | 47,470.9 | | | | | 1 | 47,470.9 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант хугацаанд 68.150.9 мянган төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 68,150.9 | | | 1 | 68,150.9 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 41,744.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 41,744.5 | | | 1 | 41,744.5 | | | | | | |
| **Дүн** | **3** | **157,366.3** | | | **2** | **109,895.4** | **1** | **47,470.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 376,755.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг, орлогын 67,678.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг, нийт 444,434.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн PDF файлаар оруулах Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал, Үнэлгээний хорооны ашиг, сонирхлын мэдүүлэг, Худалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн мэдээлэл, Ажил гүйцэтгэх гэрээнүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна. | 1 | 444,434.0 | | | 1 | 444,434.0 | | |
| **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тайлант онд спортын тэмцээний үйл ажиллагаанд 4,932.0 мянган төгрөг зарцуулсан байна. | 1 | 4,932.0 | 1 | 4,932.0 | | | | |
| **Дүн** | **2** | **449,366.0** | **1** | **4,932.0** | **1** | **444,434.0** | | |